ЦАХИМ ЗАЛИЛАНГААС СЭРГИЙЛЭХ, ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН УРЬДЧИЛСАН ТАНДАН СУДАЛГАА

Судалгааны тайлан

2026 ОН
УЛААНБААТАР ХОТ

Товъёг

Судалгааны товч дүгнэлт 3

Судалгааны хүрээ, арга зүй 4

Нэг. Асуудалд хийсэн дүн шинжилгээ 5

Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилго 10

Гурав. Зохицуулалтын хувилбарууд 11

Дөрөв. Үр нөлөөний үнэлгээ 13

Тав. Хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт 17

Зургаа. Олон улсын болон бусад улсын зохицуулалт 18

Долоо. Зөвлөмж 20

Хавсралт 1. Суурь асуултаар хийсэн үнэлгээ 25

Судалгааны товч дүгнэлт

Цахим залилангаас урьдчилан сэргийлэх, хохирлыг нэмэгдүүлэхгүй байх, хохирогчийн эрхийг хамгаалах ажиллагааг хуулийн түвшинд илүү тодорхой болгох хэрэгцээ шаардлага бий. Энэ хэрэгцээ нь залиланг шинээр гэмт хэрэгт тооцох, эсхүл цагдаа, банкны хамтын ажиллагааг анх удаа бий болгоход бус, зарим хэрэгжиж байгаа болон шинээр бий болох зарим ажиллагааны хамрах хүрээ, үүрэг, хугацаа, хяналт, эрхийн баталгааг нэг мөр болгоход оршиж байна.

2025 онд цахим орчинд үйлдэгдсэн 12,233 залилан бүртгэгдэж, нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 25.8 хувийг эзэлжээ. Тухайн жилийн мэдээлэлд 77.9 тэрбум төгрөгийн хохирол, 29.7 тэрбум төгрөгийн нөхөн төлүүлэлт туссан байна. Эдгээр нь асуудлын хэмжээ, хамгаалалтын хэрэгцээг харуулах боловч шинэ хуулийн үр ашгийг дангаараа илэрхийлэхгүй.

Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, одоо байгаа хяналт, хамтын ажиллагааг сайжруулах нь үр дүнтэй нэмэлт арга хэмжээ мөн. Гэвч бусдын хөрөнгө, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээнд хязгаарлалт тогтоох шинэ эрх, заавал биелүүлэх салбар хоорондын үүрэг, хохирогчийн шаардах эрхийг зөвхөн сургалт, гэрээ, захиргааны журмаар бүрэн бий болгох боломжгүй. Иймд энэ чиглэлээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах үндэслэлтэй.

Санхүү, харилцаа холбоо, цахим платформын үүрэг зэрэг хэрэгжих онцлогийг харгалзан, хамтын ажиллагаа, шуурхай хамгаалалт, хохирогчийн эрхэд төвлөрсөн бие даасан хууль болон зайлшгүй дагалдах өөрчлөлтийн хэрэгцээ шаардлага байгаа нь харагдаж байна.

Эрх богино хугацаагаар хязгаарлах арга хэмжээ бүрийн үндэслэл, дээд хугацаа, гомдлын журмыг хуульд бүрэн тогтоох; одоогийн тогтолцоог сайжруулах нэмэлт зардлыг тооцох; хохирогч, үйлчилгээ үзүүлэгч, зохицуулагчдын оролцоог ханган бодит ажиллагааны хугацаа, боломжийг тодорхойлох нь зүйтэй.

Судалгааны хүрээ, арга зүй

Энэхүү судалгааны зорилго нь цахим залилангаас сэргийлэх, хохирогчийн эрхийг хамгаалах асуудлыг ямар арга хэрэгслээр, ямар хүрээнд зохицуулах нь үндэслэлтэйг тогтоож, хууль санаачлагчид сонголт санал болгоход оршино.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 13.1–13.3, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу асуудлын дүн шинжилгээ, зорилго, зохицуулалтын хувилбар, үр нөлөө, хувилбарын харьцуулалт, гадаад улсын зохицуулалт, зөвлөмж гэсэн долоон хэсэгт судалгааны тайланг боловсруулав.

Нэг. Асуудалд хийсэн дүн шинжилгээ

1.1. Шийдвэрлэх асуудлын мөн чанар

Цахим залилан нь хүний итгэл, цахим таних мэдээлэл, зар сурталчилгаа, харилцаа холбоо, төлбөрийн сувгийг холбон ашиглаж эд хөрөнгө шилжүүлэн авахтай холбоотой. Хэрэглэгч өөрөө код оруулж, шилжүүлгээ баталгаажуулсан ч төлбөр хүлээн авагчийн үнэн байдал, гүйлгээний зорилгын талаар хууртагдсан байж болно. Иймээс техникийн баталгаажуулалт амжилттай болсон эсэхээр хамгаалалтын хэрэгцээг дангаар шийдэх боломжгүй юм.

Судлах асуудлыг гурван хэсэгт зааглан авч үзлээ:

1) үйлчилгээ үзүүлэгч нар залилангийн зар, дуудлага, хуурамч хаяг болон дансыг өөрсдийн хяналтын хүрээнд эрт илрүүлж, урьдчилан сэргийлэх.
2) мэдээлэл ирснээс хойш хөрөнгө цааш шилжихээс өмнө хязгаарлагдмал хүрээнд шуурхай хамгаалах.
3) хадгалж үлдсэн хөрөнгийг эрх бүхий этгээдэд буцаах, үүргийн зөрчлөөс үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх, гомдлыг үр нөлөөтэй шийдвэрлэх.

Ердийн худалдааны чанар, хүргэлт, гэрээний төлбөрийн маргааныг залиланд автоматаар тооцож болохгүй юм. Мөн эрсдэлийн дохио, үндэслэл бүхий сэжиг, гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон байдал нь өөр өөр нотолгооны түвшинтэйг харгалзах нь зүйтэй.

1.2. Цар хүрээ, өөрчлөлт

Он	Бүртгэгдсэн цахим залилан	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	Өмнөх оноос өөрчлөлт
2020	1 280	5.5%	—
2021	3 860	15.2%	+201.6%
2022	7 708	21.8%	+99.7%
2023	7 906	22.2%	+2.6%
2024	11 711	26.2%	+48.1%
2025	12 233	25.8%	+4.5%

Эх сурвалж: ЦЕГ-ын статистик

2020–2025 онд бүртгэгдсэн цахим залилангийн тоо 9.6 дахин өсжээ. Гэхдээ 2020 оны цар тахлын нөхцөл, мэдээлэх болон бүртгэх практикийн өөрчлөлт нөлөөлсөн байж болох тул уг харьцааг бодит тархалт яг ийм хэмжээгээр нэмэгдсэн гэж шууд дүгнэхэд болгоомжтой хандах нь зүйтэй. 2024–2025 онд тоо өссөн боловч нийт гэмт

хэрэгт эзлэх хувь 26.2-25.8 хувь болж буурсан нь өсөлтийн хурд, нийт бүтцийг тусад нь авч үзэх шаардлагыг харуулж байна

2023 онд 82.02 тэрбум, 2024 онд 56.9 тэрбум, 2025 онд 77.9 тэрбум төгрөгийн хохирол учирсан бөгөөд 2025 оны нөхөн төлүүлэлт 29.7 тэрбум төгрөг буюу хохирлын ойролцоогоор 38 хувь байна.

2025 оны ангилал	Тоо	Нийтэд эзлэх хувь
Банкны данс, карт, зөвшөөрөлгүй гүйлгээтэй холбоотой	2 991	24.5%
Бараа, бүтээгдэхүүний худалдаатай холбоотой	1 723	14.1%
Цахим орчин, мөнгөн шилжүүлэгтэй холбоотой	1 607	13.1%
Хөрөнгө оруулалт, мөнгө өсгөх амлалттай холбоотой	1 182	9.7%
Зээл, лизингтэй холбоотой	1 168	9.5%
Хуурамч хандив, тусламжтай холбоотой	1 022	8.4%
Бусад дөрвөн ангиллын нийлбэр	2 540	20.8%

2025 оны тохиолдлын 80.8 хувь нийслэлд бүртгэгдсэн бөгөөд хохирогчдын нийт тоо 12,158. Үүнээс 35–39 насныхан 17.3 хувь, 65-аас дээш насныхан 3 хувь байжээ.

1.3. Одоо хэрэгжиж байгаа ажиллагаа

ЦЕГ-ын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын Шуурхай ажиллагааны хэлтэс 2023.11.03–2024.11.13-нд 1,736 дуудлага, мэдээлэл хүлээн авч, 827 дуудлага, мэдээлэлтэй холбоотой 6.38 тэрбум орчим төгрөгийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон байна. 115 иргэний 1.98 тэрбум орчим төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна. Энэ нь шуурхай ажиллагааны бодит суурь байгааг нотолж байна.

1.4. Эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх этгээд, оролцогч талууд

Этгээд	Хэрэгцээ, үүсэж болох ачаалал
Хохирогч, эрсдэлд өртсөн хэрэглэгч	Нэг сувгаар шуурхай мэдээлэх, хөрөнгөө хамгаалуулах, явцаа мэдэх, баримт авах, нөхөн төлбөр шаардах
Ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн	Ойлгомжтой анхааруулга, хүртээмжтэй суваг, хууль ёсны төлөөлөл, утсаар болон биечлэн тусламж авах боломжтой байх
Банк, ББСБ, төлбөрийн болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч	Шуурхай хариу өгөх ажилтан ажиллуулах, системийн холболт, баримт хадгалалт, эрсдэлийн хяналтын үүрэг хүлээх. Үүргийн хүрээ, хууль ёсны мэдээлэл солилцооны үндэслэл тодорхой байх
Харилцаа холбоо, цахим зар, платформ, цахим худалдааны үйлчилгээ үзүүлэгч	Зар захиалагч болон хэрэглэгчийг зохих хэмжээнд шалгах, залилангийн мэдэгдэлд хариулах
Цагдаа, прокурор, шүүх, зохицуулах чиг үүрэгтэй байгууллага, ХЭҮК	Одоогийн чиг үүргийг уялдуулах, хугацаатай шийдвэр, хяналт, гомдол, мэдээллийн хамгаалалтын нэмэгдэл ачаалал

1.5. Асуудлын шалтгаан, нөхцөл

Цахим залилангийн асуудлын эхний шалтгаан нь эрсдэлийн мэдээлэл өөр өөр байгууллагад тархдаг явдал юм. Платформ зарын захиалагчийг, оператор дугаарын ашиглалтыг, банк мөнгөний хөдөлгөөнийг тус тус хяналт тавьж байна. Нэг байгууллага дангаараа бүх гинжин холбоог харахгүй байгаа гэсэн үг юм. Гэхдээ мэдээллийн сангуудыг бүхэлд нь нийлүүлэх нь зохистой шийдэл биш бөгөөд цахим залилангийн тухайн тохиолдлыг шалгахад шаардлагатай хамгийн бага мэдээллийг хуулийн үндэслэлтэй солилцох нь чухал.

Асуудал үүсэж буй дараагийн шалтгаан бол хугацааны зөрүү юм. Цахим залилангийн мөнгө олон дансаар дамжих, бэлэн мөнгө болж гарах, гадаад руу шилжих үед дараа нь гэм бурууг тогтоох ажиллагаа амжилттай байсан ч буцаан авах хөрөнгө үлдэхгүй байх явдал бий. Тиймээс хуулийн төсөлд мөнгөний хөдөлгөөний цагийн хязгааруудыг энэ шалтгаанаар шалгах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Түүнчлэн дараагийн нэг шалтгаан нь үйлчилгээ үзүүлэгч эрсдэл бууруулах боломжтой боловч энэ нь зарим талаар зардал үүсгэдэг тул тэр бүр санаачлагатай хандахгүй. Үүний зэрэгцээ хэрэглэгч эрхээ сэргээхэд шаардлагатай баримт нь хэрэглэгчээс илүү үйлчилгээ үзүүлэгчид байдаг. Тиймээс асуудлыг дан ганц “шүүхэд нэхэмжлэл гаргаж болно” гэх хандлагаар шийдвэрлэх боломжгүй.

1.6. Үйлчилж буй зохицуулалт ба нэмэлт хэрэгцээ

Зохицуулалт	Одоо байгаа хамгаалалт	Нягтлах, нэмж зохицуулах асуудал
Эрүүгийн хууль, 17.3	Цахим хэрэгсэл ашиглан залилах нь гэмт хэргийн зохицуулалтад багтана.	Урьдчилан сэргийлэх, үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг нь гэмт хэргийн асуудлаас тусдаа байх зохицуулалт хэрэгтэй
ЭХХШтХ, 26.1	Прокурорын зөвшөөрөлтэй хөрөнгийн хөдөлгөөн хянах, хязгаарлах ажиллагаа бий.	Үйлчилгээ үзүүлэгчийн эхний богино хамгаалалтаас процессын хязгаарлалтад шилжих зааг, хугацаа, шийдвэрийг тодорхой болгох шаардлагатай
Мөнгө угаахтай тэмцэх хууль, 5, 7, 11	Харилцагч таних, сэжигтэй гүйлгээ мэдээлэх; хуульд заасан нөхцөлд СМА-ны дарга хүлээгдэж буй гүйлгээг ажлын 3 хүртэл өдөр түдгэлзүүлэх боломжтой.	Залилангийн бүх мэдэгдэл мөнгө угаах сэжиг бүхий нөхцөлийг автоматаар хангахгүй. Ингэхдээ энэ 2 механизмыг давхар хугацаа шинээр эхлүүлэх хэрэгсэл болгож болохгүй.
Банкны тухай, 7.2	Банкны нууцын хуульд заасан төлбөрийн аюулгүй байдал, хэрэглэгчийн хамгаалалт бий.	Хувийн байгууллагуудын хооронд шуурхай дамжуулах мэдээллийн төрөл, зорилго, хүлээн авагчийг тодорхой болгох шаардлагатай
Мөнгөн шилжүүлэг, Иргэний хууль	Алдаатай шилжүүлэг, гэрээний үүрэг, үндэслэлгүй хөрөнгөжих, гэм хорын шаардлага гаргах боломжтой.	Хууртагдан өгсөн даалгаврыг техникийн алдаатай гүйлгээтэй адилтгахгүй. Хөрөнгө буцаалт, үйлчилгээ үзүүлэгчийн нөхөн төлбөрийг ялгах шаардлагатай.
Хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай	Мэдээлэл боловсруулах үндэслэл, мэдээллийн эзний эрх, аюулгүй байдлын үүрэг, хяналт бий.	Залилангийн мэдээлэл солилцооны үндэслэл, хадгалалтын хугацаа, алдаа залруулах нөхцөлийг тусгах шаардлагатай.
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд төр, байгууллага, иргэний оролцооны суурь бий.	Тодорхой гүйлгээ, дугаар, зарын эрсдэлд шуурхай хариулах тодорхой үүрэг, салбар хоорондын ажиллагааг нарийвчлах ёстой.
Харилцаа холбооны тухай, 25.2.6, 25.2.11	Хэрэглэгч бүртгэх; хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд үйлчилгээ зогсоохгүй байх үүрэгтэй.	Залилангийн тодорхой дугаар, үйлчилгээ хязгаарлах үндэслэл, дээд хугацаа, сэргээх ба гомдлын журмыг хуулиар тодорхойлох.
Зар сурталчилгааны тухай; Виртуал хөрөнгийн үйлчилгээний тухай	Төөрөгдүүлсэн зарын хяналт, салбарын бүртгэл, үүргийн зохицуулалт бий.	Зар захиалагч/төлбөр төлөгчийн ил тод байдал, шуурхай мэдэгдэл, баримт хадгалалт; виртуал хөрөнгийг зөвхөн бодит хяналтын хүрээнд хамгаалах.
Захиргааны,	Шийдвэрийн төрөлд тохирсон	Хувийн үйлчилгээ үзүүлэгчийн шийдвэр,

иргэний, эрүүгийн процессын хуулиуд, Эвлэрүүлэн зуучлалын тухай	гомдол, нэхэмжлэл, эвлэрлийн боломж бий.	захиргааны акт, мөрдөн шалгах шийдвэрийн харьяаллын заагийг тодорхой тусгах, холихгүй байх.

Дүгнэвэл, цахим орчин дахь болон харилцаа холбооны сүлжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар бүхэлдээ зохицуулалтгүй биш бөгөөд харин өөр өөр зорилго, эхлэх нөхцөл, шийдвэр гаргагчтай механизмыг нэг тохиолдолд хэрхэн залгуулж хэрэглэх, хэрэглэгч юу шаардах, эрх нь буруу хязгаарлагдсан хүн хэрхэн шуурхай хамгаалуулахыг нэг мөр болгох хэрэгцээ зайлшгүй байна.

Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилго

Үндсэн зорилго нь цахим залилангийн улмаас эд хөрөнгө алдах эрсдэл, хохирлын хэмжээг бууруулж, хохирогчийн эрхийг сэргээх ажиллагааг шуурхай, хүртээмжтэй болгохын зэрэгцээ гуравдагч этгээдийн эрхэд дур мэдэн халдахгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Тодорхой зорилт	Хэмжих үзүүлэлт, санал болгож буй шалгуур
1. Мэдэгдэл ба ажиллагааны хооронд алдагдахыг бууруулах	Цахим залилангийн мэдэгдэл, гомдол хүлээн авсан цаг, дамжуулсан цаг, эхний арга хэмжээний цагийг бүртгэсэн тохиолдлын хувь; бүртгэлтэй тохиолдлыг 100 хувь мөрдөх боломжтой болгох.
2. Хөрөнгө цааш алдагдахаас хамгаалах	Мэдэгдэл, гомдол ирэхэд үйлчилгээ үзүүлэгчийн хяналтад байсан холбогдох хөрөнгөөс хамгаалсан дүнгийн хувь; дараа нь бодитоор буцаасан дүнг тусад нь хэмжих.
3. Алдаатай, үндэслэлгүй хязгаарлалтыг таслан зогсоох	Хугацаа урт, үндэслэлгүй үргэлжилсэн хязгаарлалтгүй байх; мэдэгдэл, залруулга, сэргээх ажиллагааны бүртгэл 100 хувь байх. Алдаатай гэх мэт хязгаарлалтын тоо, хугацаа, учирсан хохирлыг улирал тутам тайлагнах.
4. Гомдол, буцаалтын шаардлагыг шийдвэрлүүлэх	Хуульд тогтоосон хугацаанд шийдвэрлэсэн хувь, татгалзсан үндэслэл, өөрчлөгдсөн шийдвэр, олгосон төлбөрийн дүн.
5. Хамгаалалтын хүртээмжийг хангах	Утас, цахим, биечилсэн сувгийн хүртээмж; нас, хүйс, байршил, шаардлагатай тохируулгаар ялгасан үйлчилгээний чанар. Хувийн мэдээллийг хамгийн бага хэмжээгээр ашиглах.
6. Урьдчилан сэргийлэх үүргийн хэрэгжилтийг хэмжих	Эрсдэлийн үнэлгээ, хариуцах ажилтан, баталгаажуулалт, анхааруулга, мэдээлэх сувгийн бодит ажиллагааг хянах.

Гурав. Зохицуулалтын хувилбарууд

Бүх хувилбарыг зорилгод хүрэх боломж, нэмэгдэл зардал, эрхийн эрсдэлийн ижил шалгуураар авч үзсэн бөгөөп зардлын “бага”, “дунд”, “их” гэсэн үнэлгээ нь одоо байгаа ажиллагаатай харьцуулсан үнэлгээ юм.

Хувилбар	Эерэг тал, боломж	Хязгаар, зардал; дүгнэлт
1. Шинэ зохицуулалт хийхгүй	Одоогийн цагдаа–банк, мөрдөн шалгах, салбарын хяналт үргэлжилнэ. Шилжилтийн шинэ зардал бага.	Хүлээн авах, дамжуулах, богино хамгаалалт, гомдлын баталгаа жигд болохгүй. Одоогийн тогтмол зардал, хохирол гарсаар байна. Бүх зорилгод хүрэхгүй.
2. Соён гэгээрүүлэх	Хуурамч зар таних, шуурхай мэдээлэх, нууц мэдээллээ хамгаалах чадварт нөлөөлнө. Харьцангуй бага/дунд зардал.	Мэргэжлийн луйврын арга, үйлдэлд дангаараа хүрэлцэхгүй. Бусдын хөрөнгө хязгаарлах эрх үүсгэхгүй.
3. Зах зээлийн механизм	Сайн дурын стандарт, аюулгүй үйлчилгээний өрсөлдөөн,	Мэдээллийн тэгш бус байдал, бусдад шилжих хохирол хэвээр. Даатгал шимтгэл,

	даатгал, хэрэглэгчийн сонголт.	хамрахгүй байх эрсдэлтэй.
4. Санхүүгийн интервенц	Хамтын систем, сургалт, хүртээмжийн зардлыг дэмжиж болно.	Нийт хохирлыг төсвөөс төлөх нь их, тогтворгүй зардалтай; эрсдэл бууруулах урамшууллыг сулруулж болно.
5. ТББ, хувийн хэвшлээр чиг үүрэг гүйцэтгүүлэх	Сургалт, хохирогчийн зөвлөгөө, хүртээмж, хараат бус дэмжлэгт эерэг талтай.	Төсөв, чанарын хяналт шаардлагатай. Албадлагын эрх, өмчлөл болон гэм буруу шийдвэрлэхийг гэрээгээр шилжүүлэхгүй.
6. Захиргааны шийдвэр	Одоогийн бүрэн эрхэд багтах тайлагнал, стандарт, холбоо барих цэг, ажлын горимыг шуурхай сайжруулна.	Хуулиар олгоогүй хязгаарлалт, нөхөн төлбөрийн суурийг журмаар бий болгохгүй байх шаардлагатай.
7. Хууль тогтоомжийн төсөл	Заавал биелүүлэх нийтлэг үүрэг, хязгаарлалтын хязгаар, хохирогчийн шаардах эрх, хяналтыг тогтооно.	Хэрэгжилтийн тогтмол болон нэг удаагийн зардал нэмэгдэнэ. Хэт өргөн зохицуулбал эрх, өрсөлдөөнд сөрөг. Хүрээг нарийсган сонгох нь үндэслэлтэй.

3.1. Харьцуулсан үндсэн хоёр хувилбар

А хувилбар — одоо байгаа хуулиудад уялдсан багц нэмэлт, өөрчлөлт оруулах. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нийтлэг хамтын ажиллагаа, хохирогчийн мэдээлэл хүлээн авах хэсгийг; банк, төлбөр, харилцаа холбоо, зар сурталчилгаа, мэдээлэл хамгааллын хуулиудад тухайн салбарын үүрэг, эрхийн баталгааг уялдуулан тусгана. Бүх өөрчлөлтийг нэг үзэл баримтлал, ижил нэр томьёо, зэрэг үйлчлэх хугацаатай боловсруулна.

Б хувилбар — цахим залилангийн нийтлэг эрсдэл, салбар хоорондын ажиллагаа, түр хамгаалалт, хохирогчийн эрхийг зохицуулсан бие даасан хууль, түүнд нийцүүлэх зайлшгүй өөрчлөлтүүд. Одоогийн байгууллагууд хэрэгжүүлж, цагдаагийн шуурхай нэгж хамтын ажиллагааг зохицуулна.

Хоёр хувилбарт сургалт, байгууллагын дотоод хяналт, техникийн холбоос, хохирогчид туслалцаа үзүүлэх арга хэмжээг ижил суурь нөхцөл болгон авч үзэх шаардлагатай.

Дөрөв. Үр нөлөөний үнэлгээ

4.1. Үндсэн хууль, хүний эрх, олон улсын гэрээ

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь заалтын өмчлөх эрх, 12 дахь заалтын өргөдөл, гомдол гаргах эрх, 13 дахь заалтын халдашгүй байдал, хувийн нууц, 14 дэх заалтын шүүхээр хамгаалуулах эрх, 16, 17 дахь заалтын үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийг хамтад нь харгалзан үзэх шаардлагатай. 19.1-д заасан төрийн хамгаалах үүрэг нь залилангийн хохирогчид болон үндэслэлгүйгээр эрх нь хязгаарлагдсан хүнд адил үйлчилнэ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2.3 дахь эрхээ үр нөлөөтэй хамгаалуулах, 17 дахь хувийн амьдрал, захидал харилцаанд дур мэдэн халдахгүй байх, 19 дэх мэдээлэл ба үзэл бодол илэрхийлэх, 26 дахь тэгш хамгаалалтын шаардлага нь хязгаарлалтын зорилгоос гадна хэрэглэх арга, хяналтыг үнэлэх үндэс болно.

Хөндөгдөх эрх	Эерэг нөлөө	Сөрөг эрсдэл ба зайлшгүй баталгаа
Өмчлөх, аж ахуй	Мөнгө цааш алдагдахаас	Гэм буруугүй хүлээн авагчийн орлого, цалин

эрхлэх	хамгаалж, буцаалтын боломж хадгална.	хаагдаж болно. Тиймээс зөвхөн холбоотой дүнгээр гүйлгээг хязгаарлах; бусад хөрөнгийг чөлөөтэй байлгах; хугацаа дуусмагц цуцлах зохицуулалт шаардлагатай.
Хувийн мэдээлэл, нууц	Хуурамч таних мэдээлэл, данс ашиглалтыг илрүүлэхэд тусална.	Төвлөрсөн мэдээлэл алдагдах, өөр зорилгоор ашиглах эрсдлийг бууруулах ёстой. Мэдээллийн төрөл, зорилго, хүлээн авагч, хадгалалт, хандалтын бүртгэлийг хязгаарлах; ХЭҮК-ийн хяналт байх.
Үзэл бодол, мэдээлэл, харилцаа холбоо	Залилангийн зар, хуурамч утасны дуудлагын тархалтыг бууруулна.	Залилантай холбоотой тодорхой агуулга, дугаарт чиглэх; шийдвэрийн үндэслэл, хугацаа, давж заалдах боломж олгох.
Шүүхээр хамгаалуулах	Баримт авах, хугацаатай гомдол, нөхөн төлбөр шаардах боломж нэмэгдэнэ.	Харьяалал, хуулийн хугацааг тодорхой тайлбарлах; шүүхийн хамгаалалт нээлттэй байх.
Тэгш байдал, хүртээмж	Нэмэлт туслалцаа, ойлгомжтой үйлчилгээ хамгаалалтыг хүртээмжтэй болгоно.	хяналт, тохирох зохицуулалт.

Б хувилбарт нийтлэг баталгааг нэг дор ойлгомжтой тусгах давуу талтай; харин хэт өргөн нэгтгэсэн эрх олговол эрсдэл мөн нэг дор төвлөрнө. А хувилбарт салбар бүрийн журамд баталгаа алдагдах, хугацаа зөрөх эрсдэл илүү.

4.2. Эдийн засаг, захиргааны зардал

Цахим залилангийн хохирлыг бууруулах, зөвшөөрөгдсөн мэдээлэл солилцоогоор давхар ажиллагааг багасгаж зардал хэмнэх, хэрэглэгчийн итгэлийг хадгалах нь эдийн засгийн эерэг нөлөөтэй.

Зардал хүлээгч	Нэг удаагийн нэмэгдэл	Жил бүрийн нэмэгдэл; А/Б ялгаа
Цагдаагийн шуурхай ажиллагаа	Одоогийн систем, холбоосын зөрүүг нөхөх, нэгдсэн бүртгэл, сургалт.	Ээлжийн ажилтан, холболтын үйлчилгээ, аюулгүй байдал, аудит. Хоёр хувилбарт ижил үндсэн үүрэгтэй бол зардал ойролцоо; Б-д шинэ агентлагийн зардал төлөвлөхгүй.
Монголбанк, СЗХ, ХХЗХ, холбогдох захиргааны байгууллага, ХЭҮК	Стандарт, мэдээлэх загвар, хяналтын арга, гомдлын заавар.	Хяналт, түүвэр шалгалт, мэдээлэл хамгаалалт, тайлан. А хувилбарт олон хууль, журмын уялдаа хадгалах; Б хувилбарт нийтлэг журмын зохицуулалт бий болох.
Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч	Системийн интеграц, эрсдэлийн дүрэм, төлбөр хүлээн авагчийг шалгах боломж, сургалт.	24/7 хариу арга хэмжээ, баримт хадгалалт, дотоод гомдол, дотоод аудит.
Харилцаа холбоо, платформ, зарын үйлчилгээ	Таних, мэдэгдэл хүлээн авах, хязгаарлах/сэргээх боломж	Шалгах ажилтан, тайлагнал, гомдол, баримт хадгалалт. Суурь эрхийн баталгааг хангана.
Иргэн, жижиг бизнес	Мэдээлэл, анхааруулгыг ойлгоход зарцуулах хугацаа.	Нэмэлт баталгаажуулалт. Үнэ төлбөргүй гомдол, давхар баримт шаардахгүй байх нь ачааллыг бууруулна.

Үр өгөөжийг үнэлэхдээ залилангаас үүдэх хохирлын бууралт, хохирогчийн цаг хугацааны хэмнэлт, маргаан шийдвэрлэх зардал болон байгууллагуудын ажиллагааны давхардлын бууралтыг тус тус харгалзах нь зүйтэй.

Үйлчилгээ үзүүлэгчийн буруутай эсэхээс үл хамааран залилангийн бүх хохирлыг тэднээр нөхөн төлүүлэх тогтолцоог шууд нэвтрүүлэх нь үйлчилгээний үнэ өсөх, хүртээмж хумигдах, жижиг үйлчилгээ үзүүлэгч зах зээлээс гарах эрсдэлтэй. Иймд эхний шатанд үүргийн зөрчил, учирсан хохирол, тэдгээрийн хоорондын шалтгаант холбоонд тулгуурлан хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ хэрэглэгч шаардлагаа нотлоход хэрэгтэй баримт, мэдээллийг авах боломжийг хангах нь зохистой гэж үзэв.

4.3. Нийгэм, жендэр, хүртээмж

Хохирлын улмаас өрхийн хуримтлал, бизнесийн эргэлтийн хөрөнгө алдагдах, өр төлбөр нэмэгдэхээс хамгаалах нь нийгмийн гол үр өгөөж юм. Зөвлөгөө, мэдээлэх нэг цэг, явцын мэдээлэл нь хохирогчийг байгууллага хооронд дахин дахин явуулах ачааллыг бууруулна.

Хамгаалалт цахим аппликейшнээр хязгаарлагдвал сүлжээ муутай орон нутаг, ухаалаг утасгүй, хараа/сонсголын бэрхшээлтэй хэрэглэгчид бодитоор хүртээмжгүй болно. Утас, биечилсэн болон төлөөлөгчөөр дамжуулсан хүсэлт, уншиж ойлгоход хялбар мэдэгдэл, шаардлагатай тохируулгыг хэрэгжүүлнэ.

4.4. Байгаль орчин

Өгөгдөл хадгалах, сүлжээ, тоног төхөөрөмжийн нэмэлт эрчим хүч, цахим хаягдлын шууд бус нөлөө гарч болно. Нөгөө талаас цахимаар баримт солилцох нь цаас, зорчих хөдөлгөөнийг бууруулах боломжтой.

4.5. Урьдчилан анхаарах сөрөг үр дагавар

Эрсдэл	Бууруулах арга
Хуурамч гомдлоор дансыг хаалгах	Мэдээлэл өгөгчийг баталгаажуулах, бие даасан эрсдэлийн баримт шалгах; гомдол ирснийг дангаар хязгаарлах үндэслэл болгохгүй байх.
Бүхэл бүлгийг эрсдэлтэй гэж үзэж үйлчилгээ хасах	Хувьчилсан үнэлгээ, хүний хяналт, шалтгаан тайлбарлах, өөр баримтаар таних боломж, үр дүнгийн ялгааг хянах.
Мэдээллийн санг өөр зорилгоор ашиглах, алдагдуулах	Зорилгын хязгаар, хамгийн бага мэдээлэл, эрхийн шатлал, аудит, зөрчлийн мэдэгдэл, хадгалалтын хугацаа
Залилан өөр сувагт шилжих	Бэлэн мөнгө, гадаад үйлчилгээ, өөрийн хяналтгүй хэтэвч рүү шилжсэн хэлбэрийг хэмжих; хил дамнасан хүсэлт, нотлох баримт хадгалалтыг сайжруулах.
Гомдол буурсан тоог амжилт гэж ташаа тайлбарлах	Мэдээлэх хүртээмж, татгалзсан хүсэлт, бодит хохирол, залруулгыг хамтад нь хэмжих; тайлагналын хараат бус шалгалт.

Тав. Хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт

Шалгуур	А. Уялдсан багц өөрчлөлт	Б. Тусдаа хууль + дагалдах өөрчлөлт
Зорилгод хүрэх	Шаардлагатай бүх эрх, үүргийг зэрэг тусгавал хүрэх боломжтой. Зарим нэг өөрчлөлт орхигдох эрсдэлтэй.	Нэг тохиолдлын нийтлэг ажиллагаа, эрхийн баталгааг нэг дор тогтоох боломжтой.
Хэрэглэгчид	Хэд хэдэн хуулийн хооронд лавлах	Хүсэлт, хамгаалалт, буцаалт, гомдлын

ойлгомжтой байх	шаардлага их. Нэгдсэн заавар, нийтлэг бүлгээр нөхөж болно.	үндсэн дарааллыг нэг хуулиас харах давуу талтай.
Хүний эрх	Салбар бүрд ижил баталгаа оруулбал хангаж болно; зөрүүтэй хугацаа, үндэслэлийн эрсдэл.	Нийтлэг баталгааг нэгтгэнэ; харин өргөн эрх төвлөрүүлэхээс сэргийлэх шаардлагатай.
Нэг удаагийн зардал	Олон хууль, журам, гэрээ, системийг уялдуулах зардалтай.	Шинэ хуулийн хэрэгжилт, дагалдах журам, сургалт, ижил системийн өөрчлөлттэй.
Тогтмол зардал	Ижил шуурхай ажиллагаанд үндсэн зардал адил. Олон салбарын тайлагнал давхцах эрсдэл.	Нэгдсэн бүртгэлээр давхардлыг багасгах боломжтой.
Эрх зүйн уялдаа	Нийтлэг үүрэг олон газар тархана.	Нийтлэг механизм тодорно. Банк, процесс, мэдээлэл хамгаллын хуультай зөрчилдөхөөс сэргийлж дагалдах өөрчлөлт шаардлагатай.
Хэрэгжүүлэх боломж	Салбарын зохицуулагчид өөрийн хуулиар ажиллана; хамтын ажиллагаа тодорхой байх ёстой.	Одоо байгаа байгууллагын бүрэн эрхэд тулгуурлан хамтын ажиллагааг нэгтгэх боломжтой; нэгж бүх маргааныг шийдвэрлэхгүй.

Зургаа. Олон улсын болон бусад улсын зохицуулалт

6.1. Сонголтын үндэслэл

Хууль тогтоомжийн тухай хуулийн 13.2.6-д нийцүүлэн эрх зүйн уламжлал, газар зүйн ойр байдал, зохицуулалтын арга, Монголд шилжүүлэн хэрэглэх боломжийг харгалзав. БНСУ, Тайванийг бичмэл хуулиар санхүү, харилцаа холбооны залиланд тусгай механизм тогтоосон, бүс нутгийн цахим үйлчилгээний орчинтой харьцуулах боломжтой жишээгээр сонгов. Их Британи, Австралийг нөхөн төлбөр ба салбар хооронд үүрэг хуваарилах ялгаатай шийдлийг шалгах зорилгоор нэмэв.

Гадаадын зохицуулалтын оршин байгаа баримт, Монголд тохирох эсэх тухай дүгнэлтийг ялгав. Хууль баталсны дараа залилан буурсан шалтгаант үр нөлөөг энэ судалгаагаар хэмжээгүй. Хавсаргасан харьцуулсан судалгаа, орчуулгыг туслах эх болгон ашиглаж, гол зохицуулалтыг албан ёсны хууль, зохицуулагчийн тайлбартай тулгав.

Улс, зохицуулалт	Хэрэглэж буй шийдэл	Монголд авах туршлага
Тайвань. Залилангийн гэмт хэргийн хор уршгаас сэргийлэх тусгай хууль	Санхүү, харилцаа холбоо, цахим үйлчилгээний үүргийг нэгтгэж, мэдээлэл солилцоо, үлдсэн хөрөнгө буцаах, хохирогчид туслах механизмтай. 2026.01.21-ний нэмэлт өөрчлөлттэй; зарим заалтын үйлчлэл тусдаа нөхцөлтэй.	Салбарын үүрэг болон хохирогчийн хамгаалалтыг нэгтгэх санаа тохиромжтой. Шаардлагатай хүрээ, бууутай ажиллагааны хариуцлагыг авч үзэх.
БНСУ. Харилцаа холбоонд суурилсан санхүүгийн залилангийн тусгай хууль	Сэжигтэй дансны түр арга хэмжээ, хэрэглэгчид мэдэгдэх, таних ажиллагаа, төлбөр зогсоох, шаардлага болон буцаалтын тусгай ажиллагааг зохицуулдаг.	Данс хооронд дамжих хөрөнгийг эрт хамгаалах, мэдэгдэх ба залруулах дараалал ашигтай.
Их Британи. APP залилангийн нөхөн төлбөр	2024.10.07-ноос тодорхой дотоодын шилжүүлэгт заавал нөхөн төлөх хамгаалалт хэрэгжсэн. Хамрах хэрэглэгч, төлбөрийн систем, үл	Хууртагдан зөвшөөрсөн төлбөрийг тусад нь хамгаалах, хүлээн авагч талын үйлчилгээ үзүүлэгчийн урамшууллыг тооцох нь ач

	хамаарах нөхцөл, дээд хэмжээтэй.	холбогдолтой.
Австрали. Scams Prevention Framework	Банк, харилцаа холбоо, цахим платформд урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, мэдээлэх, хариулах үүрэг хуваарилдаг. Ye шаттай хэрэгжиж, ихэнх үүрэг 2027.03.31-нээс үйлчилнэ.	Одоогийн салбарын зохицуулагчдад үүрэг хуваарилах, гомдлын нэгдсэн хүрээний санаа тохиромжтой.

6.2. Монголын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэх нь

Тайванийн зохицуулалтаас хуульд нийтлэг үүрэг тогтоогоод техникийн хэлбэр, зар захиалагчийн мэдээлэл, таних ажиллагааны нарийвчлалыг журамд шилжүүлдэг бүтцийг авч үзэж болно. Гэхдээ Монголын хууль, эрх зүйн тогтолцоонд эрх хязгаарлах үндэслэл, дээд хугацаа, гомдлын үндсэн баталгааг тогтоох шаардлагатай. Тэдгээрийг бүхэлд нь журмаар шийдэхээр үлдээх нь зохимжгүй.

БНСУ-ын буцаалтын тусгай механизмыг судлахдаа мөнгийг буцаадаг үр дүнгийн зэрэгцээ өмчлөл, гуравдагч этгээдийн эрх, олон шаардлагын эрэмбэ, гомдлын процессыг орхиж болохгүй. Монголын хувьд эхний шатанд үлдсэн хөрөнгийн эх үүсвэрийг тогтоох, маргаангүй буцаалтыг хөнгөвчлөх, маргаантай хэсгийг шүүхийн хамгаалалттай шийдвэрлэх нь илүү нийцтэй байх талтай.

Их Британийн схем нь үйлчилгээ үзүүлэгчийн бурууг тохиолдол бүрд хэрэглэгчээр нотлуулахад үүсдэг бэрхшээлийг өөр аргаар шийдсэн онцлогтой. Санаачлах хуулийн төсөл үүргийн зөрчил, шалтгаант холбоонд тулгуурласан зохицуулалт тусгах шаардлагатай.

Австралийн салбарын зохицуулагчдад үүрэг хуваарилсан зарчим нь Монголбанк, СЗХ, ХХЗХ болон бусад эрх бүхий байгууллагын одоогийн тогтолцоог ашиглахтай нийцэхээр байна.

Долоо. Зөвлөмж

7.1. Сонгосон хувилбар, зохицуулалтын хүрээ

Салбар хоорондын урьдчилан сэргийлэх үүрэг, шуурхай хамгаалалт, хохирогчийн эрхийг нэгтгэсэн бие даасан хууль болон зайлшгүй дагалдах өөрчлөлтийн багцыг боловсруулахыг зөвлөж байна.

Хуулийн үйлчлэлийг Монгол Улсад үйлчилгээ үзүүлдэг, эсхүл Монголын хэрэглэгчид чиглүүлэн үйлчилгээ санал болгодог этгээдэд хамааралтай байхаар зохицуулалтын хүрээг тодорхойлох нь зүйтэй. Гадаадын үйлчилгээ үзүүлэгчид тавих үүргийг хэрэгжүүлэх боломж, төлөөлөл, хууль ёсны хүсэлт, хил дамнасан хамтын ажиллагааг зохицуулахыг зөвлөж байна.

7.2. Хуулийн агуулгад тусгах гол шийдэл

Чиглэл	Тусгах хэм хэмжээ
Нэр томьёо, хамрах хүрээ	Зөвшөөрөлгүй гүйлгээ, хууртагдан зөвшөөрсөн шилжүүлэг, эрсдэлийн мэдээлэл, үндэслэл бүхий сэжгийг ялгах; ердийн иргэний маргааныг автоматаар залилан гэж үзэхгүй.
Байгууллагын үүрэг	Одоо байгаа хариу арга хэмжээний нэгж, салбарын зохицуулагч, үйлчилгээ үзүүлэгчийн шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хянах үүргийг ялгах.
Мэдээлэл солилцоо	Тохиолдлын дугаар, цагийн бүртгэл, шаардлагатай мэдээллийн хүрээ,

	хууль ёсны үндэслэл, хандалт, хадгалалт, залруулга, аюулгүй байдал;
Богино хугацааны хамгаалалт	Баримтад тулгуурласан шийдвэр, холбоотой дүн/үйлчилгээ, дээд хугацаа, мэдэгдэл, анхны шийдвэр гаргаагүй ажилтны шуурхай хяналт.
Буцаан олголт	Гэмт хэргийн хохирогчоор тогтоосон шийдвэрийг хүсэлт авах урьдчилсан нөхцөл болгохгүй. Шаардлага шалгах, үлдэгдэл ба эрх эзэмшигчийг тогтоох, давхар шаардлага, маргаантай хэсгийг шийдэх журмыг ялгах.
Салбарын урьдчилан сэргийлэлт	Таних, тодорхой анхааруулах, эрсдэл шалгах, зар захиалагч/төлбөр төлөгчийн мэдээлэл, дугаарын зүй бус хэрэглээг илрүүлэх, баримт хадгалах.
Хохирогчийн эрх, хариуцлага	Үнэгүй дотоод гомдол, үндэслэлтэй хариу, өөрт хамаарах баримт, хүртээмжтэй туслалцаа, шүүхийн хамгаалалт.
Хяналт, тайлагнал	Бодит буцаалт, хуулийн хугацаа, түр хязгаарлалт, гомдлын өөрчлөлт, мэдээллийн зөрчлийг нэгтгэн нийтлэх.

Хавсралт 1. Аргачлалын суурь асуултаар хийсэн үнэлгээ

А нь уялдсан багц өөрчлөлт, Б нь тусгай хууль ба дагалдах өөрчлөлт юм.

“Тийм” нь асуултаас хамаарч эерэг нөлөө эсхүл сөрөг эрсдэл байгааг заана. “Үгүй” нь тухайн шууд нөлөө санал болгож буй хүрээнд тогтоогдоогүйг илэрхийлнэ. “Нөхцөлтэй” нь аргачлалын 6.5-ын дагуу өгөгдөл, хэрэгжилт, нарийвчилсан баталгаанаас хамаарсан хариулт юм.

1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Асуулт		Үндэслэл, нөхцөл
1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм / Тийм	Ижил хамгаалалт, хувьчилсан эрсдэлийн үнэлгээ, хүртээмжийн шаардлага тусгана.
1.1.2. Ялгавартай буюу нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй / Үгүй	Алгоритм, баримт шаардах практик ялгаварлал үүсгэхгүй.
1.1.3. Эмзэг бүлгийг дэмжих арга хэмжээ эрхийн хэм хэмжээнд нийцэх эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	Нэмэлт туслалцаа, тохируулга нь шийдвэр гаргах эрхийг нь үгүйсгэхгүй байвал нийцнэ.
1.2.1. Сонголт хийхэд эмзэг бүлэг, цөөнхийн оролцоог хангасан эсэх	Үгүй / Үгүй	Энэ ажлаар шууд зөвлөлдөөгүй. 7.5-д оролцоо, асуулт, шийдвэрт нөлөөлөх асуудлыг тодорхойлсон.
1.2.2. Эрх, ашиг сонирхол хөндөгдөх хүмүүсийг тодорхойлсон эсэх	Тийм / Тийм	Хохирогч болон буруу хязгаарлалтад өртөх этгээдийг 1.4-т хамруулсан.
1.3.1. Эрхийг хамгаалахад ахиц гарах эсэх	Тийм / Тийм	Хугацаатай ажиллагаа, гомдол, баримтын хүртээмж хэрэгжвэл ахиц гарна;
1.3.2. Олон улсын гэрээ, НҮБ-ын эрхийн зөвлөмжтэй нийцэх эсэх	Тийм / Тийм	Пактын хамгаалалт, нууц, мэдээллийн эрхийг 4.1-д үнэлэв.
1.3.3. Эрх зөрчигчийн хариуцлагыг тусгах эсэх	Тийм / Тийм	Үүргийн зөрчил, учирсан хохирол, шалтгаант холбоо; нийтийн эрх зүйн хариуцлагыг дагалдах хуультай уялдуулна.
2.1. Эрхийн хязгаарлалт хууль ёсны ашиг сонирхолд нийцэх эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	Залилан таслан зогсоох, бусдын эрх хамгаалах зорилготой.
2.2. Хязгаарлалт зайлшгүй эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	Тухайн эрсдэлийг бага нөлөө үзүүлэх аргаар арилгаж болох эсэхийг шийдвэр бүрд шалгана.
3.1. Эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм / Тийм	Хэрэглэгч, хохирогч, хүлээн авагч, худалдаачин, нийтлэгч; 1.4.

3.2. Эмзэг байдлаар ялган тодорхойлсон эсэх	Тийм / Тийм	Нас, хөгжлийн бэрхшээл, хэл, орон нутаг, цахим хэрэглээний ялгаа; бодит хэрэгцээг цааш баталгаажуулна.
3.3. Эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн эсэх	Тийм / Тийм	Үнэгүй тусламж, төлөөлөл, ойлгомжтой мэдэгдэл, олон суваг санал болгосон.
3.4. Ялгаатай хэрэгцээг мэдэрсэн зохицуулалт тусгах эсэх	Тийм / Тийм	Унших, сонсох, харилцах тохируулга; ганц апп шаарддаггүй байх.
4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм / Тийм	Үйлчилгээ үзүүлэгч, цагдаа, зохицуулагч, хянагчийн үүргийг ялгана. А-д олон хууль, Б-д нийтлэг хүрээ.
5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	Ялгаатай нөлөө, өгөгдлийн дутагдлыг 4.3-т авч үзсэн.
5.2. Эрэгтэй, эмэгтэй хүнд тэгш боломж, хандлага хангах эсэх	Тийм / Тийм	Хүйсээр хамгаалалт хасахгүй; туслалцаа, мэдээллийн нууц, гомдлын ижил эрх.

2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Асуулт		Үндэслэл, нөхцөл
1.1. Дотоодын ба гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн өрсөлдөөнд нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Ижил үйлчилгээний үүрэг.
1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалт, байршилд нөлөөлөх эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	төлөөллийн шаардлага нөлөөлж болно;
1.3. Дэлхийн зах зээлийн таагүй нөлөөнөөс хамгаалах эсэх	Тийм / Тийм	Хил дамнасан залилангийн тодорхой эрсдэлийг бууруулна;
2.1. Хэрэглэгчийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	Түр саатал, нэмэлт баталгаажуулалт сонголтод нөлөөлнө.
2.2. Өрсөлдөөн хязгаарлагдсанаар үнийн хөөрөгдөл бий болох эсэх	Үгүй / Үгүй	хэмжээ нотлогдоогүй.
2.3. Шинээр зах зээлд нэвтрэгчид хүндрэл үүсэх эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	Тогтмол систем, хяналтын зардал. Үйлчилгээний эрсдэлд тохирсон техник шаардлагатай.
2.4. Шинэ монополь бий болгох эсэх	Үгүй / Үгүй	Онцгой үйлчилгээний эрх олгохгүй; нэг технологийн нийлүүлэгч албадан сонгохгүй.
3.1. Аж ахуйн нэгжид шинэ зардал үүсэх эсэх	Тийм / Тийм	Систем, ажилтан, тайлан, гомдол, аудит;
3.2. Санхүүжилтийн эх үүсвэр авахад нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Үндэслэлгүй түр хязгаарлах арга хэмжээ авахыг хориглоно.
3.3. Тодорхой бараа, бүтээгдэхүүн худалдан авахад хүргэх эсэх	Тийм / Тийм	Аюулгүй холболт, программ, тоног төхөөрөмж шаардагдаж болно; брэнд заахгүй.
3.4. Борлуулалтад хязгаарлалт, хориг тавих эсэх	Тийм / Тийм	Залилантай холбоотой зар, үйлчилгээ, гүйлгээг хязгаарлана. Хууль ёсны худалдааг хамруулахгүй.
3.5. Аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Үгүй / Үгүй	Нөлөөлөхгүй.
4.1. Мэдээлэх, тайлагнах захиргааны зардал үүсэх эсэх	Тийм / Тийм	Тиймээс давхар тайланг хасах. А хувилбарт салбар хооронд уялдуулах нэмэлт ажилтай.
5.1. Өмчлөх эрхийг хөндөх эсэх	Тийм / Тийм	Хөрөнгө түр хамгаалах, буцаах болон нөхөн төлбөрийн зохицуулалт.
5.2. Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх, хэрэгжүүлэхэд хязгаарлалт үүсэх эсэх	Тийм / Тийм	Зөвхөн холбоотой хөрөнгийн тодорхой дүн; хугацаа, гомдол, гуравдагч этгээдийн эрх тусгана.
5.3. Оюуны өмчийн эрхийг хөндөх эсэх	Үгүй / Үгүй	Хуурамч брэндтэй зар хязгаарлах нь хамгаална;
6.1. Судалгаа, шинэ бүтээлийг дэмжих эсэх	Тийм / Тийм	Залилан илрүүлэх, аюулгүй таних технологийн эрэлт нэмэгдэж болно.
6.2. Шинэ технологи, бүтээгдэхүүн	Тийм / Тийм	Тодорхой стандарт дэмжинэ;

нэвтрүүлэхийг хялбарчлах эсэх		
7.1. Хэрэглээний үнэд нөлөөлөх эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	Шимтгэл, үйлчилгээний үнэд зардал шилжих боломжтой; тооцоо дутуу.
7.2. Дотоодын зах зээл ашиглах боломж нэмэгдэх эсэх	Тийм / Тийм	Итгэл, аюулгүй байдал сайжрах боломжтой; хүртээмжгүй баталгаажуулалт эсрэг нөлөөтэй.
7.3. Хэрэглэгчийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм / Тийм	Хамгаалалт, гомдол, баримт, нөхөн төлбөрийн шаардлага тодорно.
7.4. Өрхийн санхүүгийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм / Тийм	Алдагдал буурах боломж;
8.1. Тодорхой бүс, чиглэлд ажлын байр нэмэгдэх эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	Хяналт, мэдээллийн аюулгүй байдал, гомдлын ажилтан;
8.2. Тодорхой бүс, чиглэлд ажлын байр буурах эсэх	Үгүй / Үгүй	шууд цомхотгол шаардахгүй.
8.3. Жижиг, дунд үйлдвэр, салбарт нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Эрсдэлийг бууруулна.
9.1. Улсын төсөвт нөлөөлөх эсэх	Тийм / Тийм	Төрийн ажилтан, систем, хяналт, сургалт
9.2. Шинэ байгууллага, бүтцийн өөрчлөлт шаардах эсэх	Үгүй / Үгүй	Шинэ агентлаг санал болгоогүй. Одоогийн нэгжийн орон тоо, дотоод зохион байгуулалтыг тооцно.
9.3. Төрийн захиргаанд шинэ чиг үүрэг үүсэх эсэх	Тийм / Тийм	Тодорхой тайлан, хугацааны хяналт, салбар хоорондын зохицуулалт нэмэгдэнэ.
10.1. Өсөлт, ажил эрхлэлтэд нөлөөлөх эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	Итгэл, алдагдлын бууралтын шууд бус нөлөө; макро хэмжээг тогтоогоогүй.
10.2. Хөрөнгө оруулалт, тогтвортой хөгжилд дэмжлэг болох эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	Тодорхой үүрэг, тогтвортой хэрэгжилт давуу талтай;
10.3. Инфляци нэмэгдэх эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	Салбарын үнэд нөлөөлж болох ч ерөнхий инфляцид хэмжигдэх нөлөө нотлогдоогүй.
11.1. Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх эсэх	Тийм / Тийм	Нийцнэ

3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Асуулт		Үндэслэл, нөхцөл
1.1. Шинэ ажлын байр бий болох эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	Шуурхай хариу, систем, хяналтын чиглэлээр хэрэгцээ үүснэ;
1.2. Ажлын байрны цомхотгол үүсэх эсэх	Үгүй / Үгүй	Шууд шаардахгүй;
1.3. Мэргэжлийн бүлэг, хувиараа ажил эрхлэгчдэд нөлөөлөх эсэх	Тийм / Тийм	Банк, операторын ажилтан, цахим худалдаачин, сурталчилгаа эрхлэгчид нөлөөлнө.
1.4. Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтэд нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Насаар хөдөлмөрийн хориг, давуу эрх тогтоохгүй; шууд нөлөө нотлогдоогүй.
2.1. Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм / Тийм	Хугацаатай шалгалт, баримтжуулалт, сургалт, нууцлалын шаардлага нэмэгдэнэ.
2.2. Ажилтны эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Хөдөлмөрийн хуулийн дагуу.
2.3. Ажилтны эрх, үүрэгт нөлөөлөх эсэх	Тийм / Тийм	Эрх бүхий шийдвэр, нууц мэдээлэл, гомдлын хариуцлага тодорно.
2.4. Шинэ ажлын стандарт гарах эсэх	Тийм / Тийм	Шалгах, мэдэгдэх, хязгаарлах, сэргээх, бүртгэх ажиллагааны стандарт.
2.5. Ажлын байранд технологийн шинэчлэл үүсэх эсэх	Тийм / Тийм	Холболт, дохио, лог, тайлагнал; хүний хяналтыг хадгална.
3.1. Шууд, шууд бус тэгш бус байдал үүсэх эсэх	Үгүй / Үгүй	Тогтоогдоогүй.
3.2. Эмзэг болон тодорхой бүлэгт сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй / Үгүй	Тогтоогдоогүй.
3.3. Гадаадын иргэдэд илэрхий	Үгүй / Үгүй	Иргэншлээр ялгаатай зохицуулалт байхгүй.

нөлөөлөх эсэх		
4.1. Засаглалын оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм / Тийм	Төр, үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг ба хяналтын харилцаа тодорно.
4.2. Төрийн байгууллагын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм / Тийм	Мэдэгдэл, зохицуулалт, шалгалт, тайлагнал нэмэгдэнэ.
4.3. Төрийн албан хаагчийн эрх, үүрэгт нөлөөлөх эсэх	Тийм / Тийм	Мэдээлэл хүлээн авах, хязгаарлалтад шилжих, хянах хариуцлага тодорно.
4.4. Шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм / Тийм	Гомдол, баримтын боломж сайжирна; дотоод ажиллагаа шүүхийн хамгаалалтыг хаахгүй.
4.5. Нам, ТББ-ын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	Цахим зар, хандив, данс ашигладаг тул хамрагдаж болно. Улс төрийн үзэл бодлыг залилантай адилтгахгүй.
5.1. Наслалт, өвчлөл, нас баралтад нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	тогтоогоогүй.
5.2. Дуу чимээ, агаар, хөрсөөр дамжин эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Үндсэн зохицуулалт ийм шууд эх үүсвэр үүсгэхгүй;
5.3. Хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээнд нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Энэ төрлийн амьдралын хэв маягийг шууд зохицуулахгүй;
6.1. Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм / Тийм	Хохирогчийг зөвлөгөө, тусламжид холбох; хүртээмжтэй суваг шаардлагатай.
6.2. Ажилтны боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	Давтан сургалт шаардлагатай
6.3. Боловсрол, мэргэжил, давтан сургалт авахад сөрөг нөлөөлөх эсэх	Нөхцөлтэй / Нөхцөлтэй	Үндэслэлгүй данс/холбоо хаах нь төлбөр, цахим сургалтад саад болж болно.
6.4. Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Тогтоогдоогүй
6.5. Их, дээд сургуулийн өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Сургуулийн засаглал, академик эрхийг өөрчлөхгүй.
7.1. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм / Тийм	Залилангийн боломж, хохирол бууруулах зорилготой
7.2. Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм / Тийм	Түр хамгаалалтыг тодорхой болгоно.
7.3. Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөөлөх эсэх	Тийм / Тийм	Баримт, цагийн бүртгэл, мэдээлэл солилцоо дэмжинэ;
7.4. Хохирогч, гэрчийн эрхэд сөрөг нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Мэдээлэл алдагдах, давхар шаардлага, буруутгах харилцааны эрсдэл; нууц, хүртээмж, гомдлоор хамгаална.
8.1. Соёлын өв хамгаалахад нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Шууд зохицуулалт байхгүй.
8.2. Хэл, соёлын ялгаанд нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	тохируулга хэрэгтэй.
8.3. Түүх, соёлоо хамгаалах иргэдийн оролцоонд нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Шууд нөлөө тогтоогдоогүй; хууль ёсны цахим агуулгад нийтлэг эрхийн баталгаа үйлчилнэ.

4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Асуулт	А / Б	Үндэслэл, нөхцөл
1.1. Агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй / Үгүй	Шууд эх үүсвэргүй;
2.1. Тээврийн түлшний хэрэглээг өөрчлөх эсэх	Үгүй / Үгүй	хэмжээг тооцоогүй.
2.2. Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй / Үгүй	хэмжээг тооцоогүй.
2.3. Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	улсын хэмжээнд ач холбогдолтой өөрчлөлт нотлогдоогүй.

2.4. Тээврийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй / Үгүй	Тээвэр нэмэгдүүлэх шаардлагагүй; цахим үйлчилгээ зорчилтыг багасгаж болно.
3.1. Ан амьтны тоог бууруулах эсэх	Үгүй / Үгүй	Шууд нөлөө бүхий үйл ажиллагаа төлөвлөөгүй.
3.2. Ховор амьтан, ургамалд сөрөг нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Амьдрах орчны өөрчлөлт, олборлолт санал болгоогүй.
3.3. Ан амьтны нүүдэл, суурьшилд нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Шууд нөлөө тогтоогдоогүй.
3.4. Тусгай хамгаалалттай газарт нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Шинэ газар ашиглалт санал болгоогүй.
4.1. Гадаргын, гүний болон цэвэр усны нөөцөд нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Үндсэн үйл ажиллагаа шууд нөлөөгүй;
4.2. Усны бохирдол нэмэгдэх эсэх	Үгүй / Үгүй	Ус бохирдуулах шууд үйл ажиллагаа санал болгоогүй.
4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Шууд нөлөө тогтоогдоогүй.
5.1. Хөрсний бохирдолд нөлөөлөх эсэх	Үгүй / Үгүй	Шууд нөлөө тогтоогдоогүй.
5.2. Хөрс эвдэх, ашигласан талбай нэмэгдэх эсэх	Үгүй / Үгүй	Шинэ барилга, талбай шаардах хувилбар сонгоогүй.
6.1. Ашиглаагүй газар ашиглах эсэх	Үгүй / Үгүй	Одоогийн байгууллага, дэд бүтэц ашиглана.
6.2. Газрын зориулалт өөрчлөх эсэх	Үгүй / Үгүй	Ийм зохицуулалт байхгүй.
6.3. Экологийн хамгаалалттай газрын зориулалт өөрчлөх эсэх	Үгүй / Үгүй	Ийм зохицуулалт байхгүй.
7.1. Нөхөн сэргээгдэх баялгийг зохистой ашиглах эсэх	Үгүй / Үгүй	Шууд баялгийн ашиглалт зохицуулахгүй;
7.2. Нөхөн сэргээгдэхгүй баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Үгүй / Үгүй	хэмжээ тодорхойгүй.

--oOo--